



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/201

Улаанбаатар хот

Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг
дэмжих төв НӨҮГ-ын балансаас хөрөнгө
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 17,460,500 /арван долоон сая дөрвөн зуун жаран мянга таван зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг “Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв” НӨҮГ /Д.Баярсайхан/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /Ш.Үнэнбат/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг “Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв” НӨҮГ /Д.Баярсайхан /-д, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /Ш.Үнэнбат/-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

11500000505

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
 даргын 2020 оны ...05... дугаар сарын06..... өдрийн
 1/201... тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: "Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв" НӨҮГ

Д/Д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Сандал сургалт	саарал	9	ш	16	45,000.00	720,000.00	606,000.00	114,000.00	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар
2	Уулзалтын ширээ	шаргал	5	ш	2	653,250.00	1,306,500.00	631,475.00	675,025.00	
3	Индэр	бор	5	ш	1	560,000.00	560,000.00	275,333.53	284,666.47	
4	Дрож	улаан	5	ш	116	50,000.00	5,800,000.00	2,851,666.47	2,948,333.53	
5	Сургалтын ширээ	саарал	5	ш	20	250,000.00	5,000,000.00	2,458,333.53	2,541,666.47	
6	Шүүгээ тавиур	шаргал	5	ш	4	320,750.00	1,283,000.00	630,808.53	652,191.47	
7	Ширээ бичгийн саарал	саарал	7	ш	2	570,500.00	1,141,000.00	1,141,000.00	-	
8	Номын шүүгээ СМТ	шилэн хаалгата	5	ш	2	825,000.00	1,650,000.00	1,100,000.00	550,000.00	
	Тавилга эд хогшлын дүн				163.00	3,274,500.00	17,460,500.00	9,694,617.06	7,765,882.94	